



## **“МОНГОЛ ДААТГАЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН АШИГ ХУВААРИЛАЛТЫН БОДЛОГО**

### **НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

- 1.1. Энэхүү журмын зорилго нь компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс баримтлах ашиг хуваарилалтын бодлого, хуваарилах нөхцөл журмыг “Компанийн тухай” хууль, Монголын компанийн засаглалын кодекс, компанийн дүрэмд нийцүүлэн тодорхойлоход оршино.
- 1.2. “Монгол Даатгал” ХК-ийн дүрмийн 3.1-д зааснаар компани нь ашгийн төлөө үндсэн зорилготой.
- 1.3. Компани нь ашгийн төлөө хуулийн этгээд бөгөөд компанийн дүрмийн 3.1-д зааснаар “... хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийг өсгөх нь компанийн үндсэн зорилго мөн” гэж заасан нь компанийн ашиг хуваарилалтын зарчмыг тодорхойлно.
- 1.4. Энэхүү журмаар компанийн ашгийг хуваарилах асуудлаар ТУЗ-ийн шийдвэр гаргахад баримтлах үндсэн зарчмыг тодорхойлно.
- 1.5. ТУЗ нь “Ашиг хуваарилалтын бодлого”-ыг нийтийн хүртээл болгох үүрэгтэй. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хариуцан уг журмыг компанийн сайтад байрлуулах замаар нийтэд нээлттэй байлгах үүрэг хүлээнэ.

### **ХОЁР. АШИГ ХУВААРИЛАХ ЗАРЧИМ, АШИГ ХУВААРИЛАХ ТУХАЙ ШИЙДВЭР**

- 2.1. Компани ногдол ашиг хуваарилах “Үлдэгдлийн зарчим”-ыг баримтална.
- 2.2. Энэ журмын 2.1-д заасан зарчмын дагуу компанийн жилийн санхүүгийн тайланд тусгагдсан цэвэр ашгаас компанийн үйл ажиллагааны бизнес төлөвлөгөө төсөлд тусгагдсаны дагуу дотоод эх үүсвэрээр санхүүжүүлэхэд зориулан хуваарилах хэсэг болон ТУЗ-ийн шийдвэрээр хөгжлийн санд хуваарилахаар шийдвэрлэсэн хэсгийг хасаад үлдэх ашгийг ногдол ашиг болгон хуваарилна.
- 2.3. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т заасны дагуу компани нь дараа жилийн 2 дугаар сарын 10-ны дотор жилийн санхүүгийн тайлангаа гаргаж, харилцах санхүүгийн байгууллагад хүргүүлсэн байна.
- 2.4. Санхүүгийн тайлан гарснаас хойш 20 хоногийн дотор буюу жил бүрийн 3 дугаар сарын 1-ний дотор санхүүгийн тайланд тусгагдсан ашгийг хэрхэн хуваарилах тухай шийдвэрийг ТУЗ гаргана.
- 2.5. Ашиг хуваарилах тухай шийдвэрийг Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан маягтаар Хороо, Монголын хөрөнгийн биржид хүргүүлэх бөгөөд компанийн цахим хуудсанд тавьж нийтэд мэдээлнэ. Мөн түүнчлэн хувьцаа эзэмшигчдийн хуралд зориулсан мэдээлэлтэй хамт хүргүүлнэ.
- 2.6. Жилийн тайланд тусгах мэдээлэлд ногдол ашгийн хэмжээг тодорхойлсон үндэслэлийг дэлгэрэнгүй тусгасан байх бөгөөд ногдол ашиг хуваарилахгүйгээр шийдвэрлэсэн бол түүний үндэслэлийг энэ журмын дагуу тайлбарласан байна.

### **ГУРАВ. НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ НӨХЦӨЛ, ТАЙЛАГНАХ**

- 3.1. Компанийн татвар төлсний дараах цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилна.

- 3.2. Дараах нөхцөлд компанийн ашгаас ногдол ашигт хуваарилалт хийнэ:
- 3.2.1. хуваарилалт хийсний дараа компани нь төлбөрийн чадвартай байх;
  - 3.2.2. хуваарилалт хийсний дараа компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь компанийн дүрмийн 10.3-д заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнээс багагүй байх;
- 3.3. Ногдол ашгийн хуваарилалт хийсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь 25-аас дээш хувиар багассан тохиолдолд компани нь ногдол ашиг хуваарилж эхэлсэн өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор зээлдүүлэгчид өөрийн хөрөнгийн үлдэгдлийн хэмжээг бичгээр мэдэгдэнэ.
- 3.4. Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрт ногдол ашгийг олгож эхлэх хугацааг заасан байх бөгөөд энэ хугацаанд ногдол ашгийг олгож эхэлсэн байх ёстой. Ногдол ашгийг хугацаанд нь олгохгүй байгаа талаар хувьцаа эзэмшигчдээс гомдол гаргасан нь үндэслэлтэй болох нь нотлогдвол гүйцэтгэх захиралд сануулах, цалинг тодорхой хугацаагаар, тодорхой хувиар бууруулах, ажлаас халах зэрэг арга хэмжээг ТУЗ-ийн шийдвэрээр оногдуулна.
- 3.5. Ногдол ашиг хуваарилсны дараа үлдэх ашгаас компанийн дотоод сан тусгай зориулалтын сан байгуулж болно. Сан байгуулах асуудлыг ТУЗ шийдвэрлэнэ. Санг байгуулах түүний хөрөнгийг зарцуулах журмын төслийг гүйцэтгэх захирал боловсруулж, ТУЗ-өөр батлуулж, мөрдөнө.
- 3.6. Тусгай зориулалтын санд хөрөнгө хуваарилсан улирлын санхүүгийн тайлан гаргах үед “Ашиг хуваарилалтын тайлан”-г гаргаж, үйл ажиллагааны тайлангийн хамт хувьцаа эзэмшигчдэд хүргэх бөгөөд Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлнэ.
- 3.7. Хувьцаа эзэмшигчдийн жилийн ээлжит хуралд өмнөх жилийн ногдол ашиг хуваарилалтын тайланг танилцуулна.

